

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ТАНХИМД**

2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

Хяналтын журмаар гомдол гаргах тухай

Гомдол гаргагч: “Баян Их Үйлс” ХХК /Регистрийн дугаар: 4251202/
Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан, 10-р баг, 5-р хороолол, 1а байр, 85 тоот
Холбогдох утас: 8801-4198, 9907-5909

Гомдлын шаардлага: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 221/МА2024/0088 дугаартай магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хангуулах тухай

Гомдлын үндэслэл: Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 128/ШШ2023/0817 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 221/МА2024/0088 дугаартай магадлалыг 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр гардан авч танилцаад Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1-д заасны дагуу шүүхийн хууль хэрэглээний зөрүүг буюу анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний ялгаатай үндэслэлийг арилгуулахаар шийдвэр, магадлалыг бүхэлд нь эс зөвшөөрч хяналтын журмаар гомдол гаргаж байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлалын хянавал хэсгийн 6 дахь хэсэгт “хүчингүй болсон хэм хэмжээг маргаан бүхий захиргааны актад хэрэглэсэн” талаарх нэхэмжлэгчийн гомдлын үндэслэлийг хууль зүйн талаас нь үгүйсгэсэн ямар нэгэн дүгнэлт өгч чадаагүй, харин баримтаар үгүйсгэгдэнэ гэх зэргээр адаатай дүгнэлт өгч байгаа нь анхан шатны шүүхийн дүгнэлтээс илт зөрүүтэй гэж үзэхээр байна.

Учир нь анхан шатны шүүхээс хариуцагч нь маргаан бүхий актыг үйлдэхдээ тухайн цаг хугацаанд хүчин төгөлдөр үйлчилж байсан хэм хэмжээг нөхөж хэрэглэсэн нь буруу биш гэсэн бол давж заалдах шатны шүүхээс хүчингүй болсон хэм хэмжээг хэрэглэсэн нь хэрэгт авагдсан баримтаар зөвтгөгдөж байх тул гэх зэргээр зөрүүтэй дүгнэлт өгсөн байна.

Угтаа аль ч тохиолдолд буюу анхан шатны шүүх ч тэр, давж заалдах шатны шүүх ч тэр хүчингүй болсон хэм хэмжээ буюу татвар төлөгчийн эрх зүйн байдлыг дордуулсан хэм хэмжээг нөхөн хэрэглэж байгаа нь хууль хэрэглээний зарчимд харш юм. Өөрөөр хэлбэл: Тухайн цаг хугацаанд хүчинтэй мөрдөгдөж байсан үндэслэлээр Үндсэн хуульд харшилсан хууль, хэм хэмжээг түр баталж эрх бүхий байгууллагаас хүчингүй болгох хүртэл нь хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчиж болно гэх агуулгаар дүгнэлт өгч байгаад харамсалтай байна. Энэхүү хууль хэрэглээний гажуудлыг Улсын Дээд шүүхээс таслан зогсоож өгнө гэдэгт найдаж байна.



Нэг. Анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг буруу тайлбарлан зөрүүтэй хэрэглэсэн тухайд:

1.1 Хүчингүй болсон хэм хэмжээг хэрэглэсэн хариуцагчийн үйлдлийг зөвтгөхдөө хуулийг буруу тайлбарласан тухайд:

Анхан шатны шүүхээс маргаан бүхий актын хууль зүйн үндэслэл болох Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэсэн, мөн түүнчлэн татвар төлөгчийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгчийн “худалдахаар ачуулсан” этгээд байна гэх зэргээр алдаатай үндэслэлгүй дүгнэлт хийсэн байдаг. Гэтэл давж заалдах шатны шүүхээс уг дүгнэлтийг эсрэгцүүлсэн байдлаар буюу төмрийн баяжмалыг гаргасан болох нь гаалийн экспортын мэдээгээр тогтоогдож байна гэж алдаатай дүгнэлт өгсөн. Угтаа хууль хэрэглэний үүднээс яагаад анхан шатны шүүх Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэм хэмжээг хэрэглэсэн нь зөв болсон эсэх талаас нь бус хэрэгт авагдсан баримтыг иш татаж байгаа нь буруу юм.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь заалт, мөн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 4-т заасныг тус тус үндэслэсэн анхан шатны дүгнэлттэй холбогдуулж давж заалдах шатны шүүхээс ямарч дүгнэлт хийгээгүй нь хуулийг буруу хэрэглэсэн гэж үзнэ.

Учир нь Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоосон шийдвэр эрх бүхий байгууллагаас гарсан нь тухайн хэм хэмжээг дахин хэрэглэх байдлаар татвар төлөгчийн эрх зүйн байдлыг дордуулах учиргүй болохоос хүчинтэй байх хугацаандаа хэрэглэгдэнэ гэх байдлаар буруу тайлбарлаж хуулийн зорилгыг үгүйсгэж болохгүй юм.

Өөрөөр хэлбэл: Хуульд нийцээгүй хэм хэмжээг нөхөх байдлаар дахин хэрэглэх үндэслэлийг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр бүр мөсөн хааж байгаа хэлбэр болохоос хүчинтэй байх хугацаанд нь тохируулан хэдийд ч хэрэглэнэ гэх хуулийн агуулгыг илэрхийлээгүй болно.

Товчхондоо: Татвар төлөгчийн ч бай, хувь хүн хуулийн этгээдийн эрхийг хохироохын тулд Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэхгүй хуулийг батлах замаар зорилгодоо хүрэх явцуу сонирхлыг бий болгож болохгүй юм. Хуульд нийцэхгүй хэм хэмжээ хүчингүй болох хүртэл нь хүний эрх, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох зорилгыг хуулийн зохицуулалт хэзээ ч агуулж болохгүй юм.

Нэхэмжлэгчийн зүгээс маргаан бүхий акт хууль зүйн үндэслэлгүй гэж маргаж буй үндэслэлийн голлох шалтгаан нь Үндсэн хуульд нийцээгүй болох нь нэгэнт тогтоогдсон хуулийн хэм хэмжээг цаг хугацааны хувьд хэдийд хэрэглэж байгааг нь онцгой анхаарах нь зүйтэй юм.

Тухайлбал: Хариуцагч нар нь татвар төлөгч компанийн 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр №НА21220000080 дугаартай маргаан бүхий актыг үйлдсэн байдаг.

Тодотговол: Маргаан бүхий актын хуулийн үндэслэл болох Ашигт малтмалын тухай хуулийн 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт нь мөн оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 04 дугаартай тогтоолоор хүчингүй болсон байдаг. Энэ тохиолдолд хариуцагч нар нь маргаан бүхий актыг 2022 онд үйлдсэн буюу хожим үйлдэж байгаа тул нэгэнт хүчингүй болсон хэм хэмжээг бус хүчин төгөлдөр хэм хэмжээг буюу татвар төлөгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн, Үндсэн хуульд нийцсэн хэм хэмжээг хэрэглэх нь хууль хэрэглээний хувьд зөв юм.

Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүхээс хуулийн холбогдох заалтуудыг илт буруу тайлбарлаж буюу хүчингүй болохыг тогтоосон цэцийн шийдвэр гарснаас хойш үйлчлэх бөгөөд хүчин төгөлдөр байх хугацаандаа үйлчлэлээ алдахгүй гэх зэргээр алдаатай дүгнэлт өгсөн байна.

Учир нь хүчингүй болсон хэм хэмжээг маргаан бүхий актыг үйлдэхдээ буюу 2022 онд хэрэглэж байгаа гэдгийг хоёр шатны шүүх анхаарч энэ талаар дүгнэлт өгөөгүй нь хуулийг зөрүүтэй тайлбарлан хэрэглэсэн гэж үзэхээс өөр аргагүй байна.

1.2 Маргаан бүхий актад алданги, торгууль тооцсон хуулийн үндэслэлийг зөрүүтэй хэрэглэсэн тухайд:

Татварын нөхөн ногдуулалтын актын хоёр дахь хуудсанд татварын алданги, торгуулиас чөлөөлсөн тухай дурьдаад тухайн хугацаанд төлвөл зохих татварт алданги, торгууль ногдуулаагүй болно., гэж заасан атлаа торгууль, алданги ногдуулсан нь логик алдаатай гэж үзнэ.

Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд заасан "2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд албан татвар төлөгчийн хуулийн-дагуу ногдуулан тайлагнасан төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн албан татвар төлөгчийг нэг удаа чөлөөлсүгэй" гэж заасныг буруу тайлбарлан хуулийг алдаатай хэрэглэсэн байна.

Анхан шатны шүүхээс дээрх хуулийн заалт нь нэхэмжлэгч компанид хамааралгүй, учир нь хуульд заасан хугацаанд ашигт малтмалын нөөц ашигласны тайлангаа гаргаж өгөөгүй, тайлагнаагүй тул хуулийн заалтыг хэрэглэх үндэслэл бүрдээгүй гэх алдаатай дүгнэлтийг өгсөн байна.

Тухайлбал: Хэрэгт авагдсан баримтаар татвар төлөгч 2020 оны 2 дугаар улирлын тайлангаа хуульд заасан хугацаа, үндэслэл журмын дагуу тайлагнасан болох нь тогтоогдсон,



татварын байгууллага бүртгэж татварын нэгдсэн систем дээр баталгаажуулсан, талууд 2 дугаар улирлын тайлангийн талаар маргаан байдаггүй болно.

Гэтэл нэхэмжлэгч талыг татвар ногдуулан тайлагнах үүргээ биелүүлээгүй тул гэх илэрхий алдаатай дүгнэлт өгч улмаар "Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай" хуулийн үйлчлэл хамааралгүй гэж дүгнэсэн анхан шатны шүүхийн алдаатай дүгнэлтгүй холбоотойгоор давж заалдах шатны шүүхээс дүгнэлт өгөлгүй орхигдуулсан байна.

Иймд, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 128/ШШ2023/0817 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 221/МА2024/0088 дугаартай магадлалыг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж өгнө үү.

Гомдол гаргасан:

Нэхэмжлэгчийн өмгөөлөгч:



Б.Бадамжаргал

Утас: 8801-4198